



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/428

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хурдан морины уралдааны зам засах, наадмын талбай, аймгийн баяр наадмын төв цэнгэлдэх хүрээлэнгийн хашааны гаднах гарц, гарамын ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Ганзориг - Мэргэжлийн хяналтын авто замын улсын байцаагч

Ц.Цогтбаяр - Жаргалант сумын Засаг даргын орлогч


Н.Балжинням - Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Нарийн бичгийн дарга:

Ц.Сувдаа - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Хурдан морины уралдааны зам засах, наадмын талбай, аймгийн баяр наадмын төв цэнгэлдэх хүрээлэнгийн хашааны гаднах гарц, гарамын ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН